МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

# Ёс зүйн дэд хорооны талаар

## Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



# АГУУЛГА

- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ГОЛ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ, НИЙТЛЭГ ХЭМ ХЭМЖЭЭ, ШААРДЛАГА
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН АСУУДАЛ ЭРХЛЭХ ЭТГЭЭД
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



# Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал

1. Авлигаас ангид байх
2. Сонирхлын зөрчил гаргахгүй байх
3. Өөрийн өмч хөрөнгийг мэдүүлж байх
4. Илт хууль зөрчсөн захиргааны шийдвэр гаргахгүй байх
5. Төрийн албаны үнэт зүйлс, эрхэм зорилгод харш үйлдэх гаргахгүй байх
6. Байгууллагын дотоод дүрэм,  журмыг сахих, соёлд хүндэтгэлтэй хандах
7. Олон нийтийн өмнө төрийн албан хаагчийн хувиар биеэ зохистой, үлгэр жишээч авч явах, эерэг харилцаа, хандлагатай байх
8. Хүрээлэн буй орчинд ээлтэй, нийтийн сайн үйлст манлайлагч байх

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН АСУУДАЛ ЭРХЛЭХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД, БҮРЭН ЭРХ

- Төрийн албаны Зөвлөлийн дэргэд Ёс зүйн Хороо
- Ёс зүйн дэд хороо
- Томилох эрх бүхий этгээд

# Дэд хороо

- Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо
- Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд Хороо

# ТӨБЗГ-ын дэргэдэх Ёс зүйн дэд хороо

- Албан хаагчийн тооноос хамааран 3-7 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.
- Албан хаагчдын дундаас сонгогдоно. Даргыг гишүүд дотроосоо сонгоно.
- Хугацаа 5 жил



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 4 сарын 1 өдөр    Дугаар А/40    Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо
байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 13.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ёс зүйн дэд хорооны дарга:

| | |
|---|---|
| Н.Ганболд | Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга |
| Гишүүд: | |
| Д.Дэлгэрмаа | Хууль, эрх зүйн хэлтсийн дарга |
| В.Дарханбаатар | Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны дарга |
| Д.Отгонтуяа | Ерөнхий нягтлан бодогч |
| Г.Туул | Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| Нарийн бичгийн дарга Н.Дэгиймаа | Хүний нөөцийн мэргэжилтэн |

2.Байгууллагын ажиллагсдыг ёс зүйн зөрчил гаргуулахгүй байхад чиглэсэн урьдчилан сэргийлэх, сөрөг үр дагаврыг арилгах ажлыг зохион байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хянан шалгаж дүгнэлт гаргах, холбогдох тайлан мэдээг Ёс зүйн хороонд хүргүүлж ажиллахыг Ёс зүйн дэд хороо /Н.Ганболд/-д даалгасугай.

3. Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллыг сар бүрийн албан тушаалын үндсэн цалингаас 20 хувиар тооцон олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Отгонтуяа/-д зөвшөөрсүгэй.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн А/24 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА    Б.ЦЭНГЭЛ 13701Э812

ТӨБЗГ тушаал-2024

# Бүрэн эрх

- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, **дүгнэлт гаргах;**
- Дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;
- Харьяа байгууллага, бүтцийн нэгжид ёс зүйн асуудлаар **зөвлөмж өгөх**;
- Үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах;
- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж **Ёс зүйн хороонд хүргүүлэх;**
- Бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ

**Томилох эрх бүхий албан тушаалтан Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн дараах шийдвэрийг гаргана:**

- Гомдол гаргагчид, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох;
- Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах;
- Байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах;
- Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах

- Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол ёс зүйн хариуцлага хүлээлгэхгүй.

- Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн өдрөөс хойш нэг жилийн дотор ёс зүйн зөрчил гаргаагүй бол түүнийг ёс зүйн шийтгэлгүйд тооцно.

# Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар тайлагнах, олон нийтэд мэдээлэх

- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй бол энэ талаарх мэдээллийг нийтэд мэдээлнэ.
- Хороо, дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтан энэ хуульд заасан журмын дагуу тайлан, мэдээлэл гарган дээд шатны байгууллагадаа хүргүүлж, байгууллагын цахим хаягт байршуулна.

# БАЯРЛАЛАА